



**ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2017 оны 03 сарын 14 өдөр

Дугаар 24

Есөнбулаг сум

Журам батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.12 дахь хэсгийг үндэслэн ТОГТООХ нь:


1. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шагналын журамд нэмэлт өөрчлөлт оруулж хавсралтаар баталсугай.

2. Шагналын журмыг мөрдөж ажиллахыг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /А.Мөнхтөр/-д даалгасугай.

3. Журамд нэмэлт өөрчлөлт оруулсантай холбогдуулан аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2013 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн 19 дүгээр тогтоолыг хүчингүй болгосугай.

ДАРГА  Т.ГАНЗОРИГ

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны
03 сарын 14 ний өдрийн 24 дүгээр
тогтоолын хавсралт



АЙМГИЙН ИТХ-ЫН ШАГНАЛЫН ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

Аймгийн эдийн засаг нийгмийн хөгжилд бодитой хувь нэмэр оруулан, Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагыг төлөвшүүлэн хөгжүүлэх, Нутгийн удирдлагын тогтолцоог боловсронгуй болгоход үр бүтээлтэй ажиллаж байгаа хүмүүсийг шалгаруулан аймгийн ИТХ-ын нэрэмжит шагнал “Алтан угалз”, ИТХ-ын даргын нэрэмжит шагнал “Хүндэт жуух бичиг”-ээр шагнахад энэхүү журмыг мөрдөнө.

Хоёр. Шагналын ангилал

- 2.1. Аймгийн ИТХ-ын нэрэмжит шагнал нь “Алтан угалз” цом, өргөмжлөл
- 2.2. ИТХ-ын даргын нэрэмжит шагнал нь “Хүндэт жуух бичиг” байна.

Гурав. Шагнал олгох үндэслэл

3.1. Аймгийн ИТХ-ын нэрэмжит шагнал олгохдоо

Улс, аймгийн эдийн засаг нийгмийн хөгжилд бодитой хувь нэмэр оруулан, Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагыг төлөвшүүлэн хөгжүүлэх, Нутгийн удирдлагын тогтолцоог боловсронгуй болгоход үр бүтээлтэй ажиллаж байгаа Говь-Алтай аймгийн харьяат иргэд, төрийн албан хаагчдыг харьяа байгууллагын тодорхойлолтыг үндэслэн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлэн шалгаруулж шагнана.

3.2. Аймгийн ИТХ-ын даргын нэрэмжит шагнал олгохдоо

Амжилт бүтээл нь орон нутаг, хамт олондоо үнэлэгдсэн, төрийн албан хаагчид, иргэд, бизнес эрхлэгчид, аж ахуйн нэгж байгууллагын ажилтан, сурлага, урлаг спортын өндөр амжилт гаргасан оюутан, сурагчид мөн НӨУБ-ын үйл ажиллагааны хөгжил, төлөвшилд бодитой хувь нэмэр оруулж амжилт гаргасан шат шатны хурлын Төлөөлөгчид, /БИНХ-ын дарга нар/-ыг тухайн харьяа байгууллагын тодорхойлолтыг үндэслэн шалгаруулж ИТХ-ын даргын захирамжаар шагнана.

Дөрөв. Шагнал олгох шалгуур

4.1. Аймгийн ИТХ-ын нэрэмжит шагналыг Төрийн болон хувийн хэвшлийн байгууллагад 10-аас доошгүй жил ажилласан, ажлын амжилт нь жигд өссөн байх, тив, дэлхийн хэмжээний уралдаан тэмцээнд амжилт гаргасан байх

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны
03 сарын 14 ний өдрийн 24 дүгээр
тогтоолын хавсралт



АЙМГИЙН ИТХ-ЫН ШАГНАЛЫН ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

Аймгийн эдийн засаг нийгмийн хөгжилд бодитой хувь нэмэр оруулан, Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагыг төлөвшүүлэн хөгжүүлэх, Нутгийн удирдлагын тогтолцоог боловсронгуй болгоход үр бүтээлтэй ажиллаж байгаа хүмүүсийг шалгаруулан аймгийн ИТХ-ын нэрэмжит шагнал “Алтан угалз”, ИТХ-ын даргын нэрэмжит шагнал “Хүндэт жуух бичиг”-ээр шагнахад энэхүү журмыг мөрдөнө.

Хоёр. Шагналын ангилал

- 2.1. Аймгийн ИТХ-ын нэрэмжит шагнал нь “Алтан угалз” цом, өргөмжлөл
- 2.2. ИТХ-ын даргын нэрэмжит шагнал нь “Хүндэт жуух бичиг” байна.

Гурав. Шагнал олгох үндэслэл

3.1. Аймгийн ИТХ-ын нэрэмжит шагнал олгохдоо

Улс, аймгийн эдийн засаг нийгмийн хөгжилд бодитой хувь нэмэр оруулан, Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагыг төлөвшүүлэн хөгжүүлэх, Нутгийн удирдлагын тогтолцоог боловсронгуй болгоход үр бүтээлтэй ажиллаж байгаа Говь-Алтай аймгийн харьяат иргэд, төрийн албан хаагчдыг харьяа байгууллагын тодорхойлолтыг үндэслэн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлэн шалгаруулж шагнана.

3.2. Аймгийн ИТХ-ын даргын нэрэмжит шагнал олгохдоо

Амжилт бүтээл нь орон нутаг, хамт олондоо үнэлэгдсэн, төрийн албан хаагчид, иргэд, бизнес эрхлэгчид, аж ахуйн нэгж байгууллагын ажилтан, сурлага, урлаг спортын өндөр амжилт гаргасан оюутан, сурагчид мөн НӨУБ-ын үйл ажиллагааны хөгжил, төлөвшилд бодитой хувь нэмэр оруулж амжилт гаргасан шат шатны хурлын Төлөөлөгчид, /БИНХ-ын дарга нар/-ыг тухайн харьяа байгууллагын тодорхойлолтыг үндэслэн шалгаруулж ИТХ-ын даргын захирамжаар шагнана.

Дөрөв. Шагнал олгох шалгуур

4.1. Аймгийн ИТХ-ын нэрэмжит шагналыг Төрийн болон хувийн хэвшлийн байгууллагад 10-аас доошгүй жил ажилласан, ажлын амжилт нь жигд өссөн байх, тив, дэлхийн хэмжээний уралдаан тэмцээнд амжилт гаргасан байх

4.2. Аймгийн ИТХ-ын даргын нэрэмжит шагналыг Төрийн болон хувийн хэвшлийн байгууллагад 5-аас доошгүй жил ажилласан, ажлын амжилт жигд өссөн байх, улс, бүсийн хэмжээний уралдаан тэмцээнд амжилт гаргасан байх, аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжилд бодитой хувь нэмэр оруулсан байх

Тав. Шагналд нэр дэвшүүлэх тодорхойлох

5.1. Говь-Алтай аймгийн ИТХ-ын болон ИТХ-ын даргын нэрэмжит шагналаар шагнуулах иргэний тодорхойлолт, хавсралт материалыг салбарын удирдлага болон үндсэн байгууллагаас аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн Ажлын албанд ирүүлсэн байна.

5.2. Шагналд нэр дэвшиж буй иргэн энэ журмын гурав болон дөрөвдүгээр бүлэгт заасан үндэслэл, шалгуурыг хангасан байна.

5.3. Өмнө нь авсан төрийн болон аймгийн гавьяа, шагналаас хойш ажлын амжилт нь ахисан байна.

5.4. Энэ журмын 3 дугаар бүлгийн 2 дахь хэсэгт заасан шат шатны хурлын Төлөөлөгчид, БИНХ-ын дарга нарыг шагнуулах санал тодорхойлолтыг аймгийн ИТХ-ын дарга, Тэргүүлэгчид санаачлан гаргаж болно.

5.5. ИТХ-ын нэрэмжит шагналаар шагнуулах санал тодорхойлолтыг аймгийн ИТХ-ын дарга, Тэргүүлэгчид болон аймгийн Засаг дарга санаачлан гаргаж болно.

5.6. Шагнуулахаар нэр дэвшүүлсэн хүний тодорхойлолт, хавсралт материалыг дор дурдсаны дагуу бүрдүүлнэ.

а/ Албан хүсэлт

б/ Тухайн салбар, хэлтэс, агентлаг, байгууллагын даргын тодорхойлолт

в/ Шагнуулах иргэний анкет

г/ Зэрэг цол, гавьяа шагналын үнэмлэх

Зургаа. Шагнахаар шийдвэрлэх, олгох

6.1. Аймгийн ИТХ-ын нэрэмжит болон ИТХ-ын даргын нэрэмжит шагналд тодорхойлсон иргэний материалыг аймгийн ИТХ-ын Ажлын алба энэхүү журмын дагуу жил бүрийн 01дүгээр сард багтаан хүлээн авч, судлан аймгийн ИТХ-ын дарга, Тэргүүлэгчдэд танилцуулна.

6.2. Шагналын материалтай ИТХ-ын дарга танилцаж, Тэргүүлэгчид хэлэлцээд шагнал олгох талаар аймгийн ИТХ-ын даргын захирамж, Тэргүүлэгчдийн тогтоол гаргана.

Долоо. Үндсэн шагнал

7.1 Аймгийн ИТХ-ын нэрэмжит шагналд “Алтан угалз” цом, өргөмжлөл, мөнгөн шагнал байна.

7.2. Аймгийн ИТХ-ын даргын нэрэмжит шагналд “Хүндэт жуух бичиг”-ийг баримтжуулсан хавтас бүхий үнэмлэх, мөнгөн шагнал байна.

Найм. Шагналд дагалдах мөнгөн шагнал

8.1. Аймгийн ИТХ-ын нэрэмжит шагналаар шагнахад гарах зардлыг оролцуулаад 600.000 төгрөг байна. Жилд 1-2 хүнийг шагнаж урамшуулна.

8.2. Аймгийн ИТХ-ын даргын нэрэмжит шагналаар шагнахад гарах зардлыг оролцуулаад 100,000 төгрөг байна.

8.3 Салбарын болон байгууллагын тэгш ойн жил тохиосон, аймаг орон нутгийн эдийн засаг, нийгмийн хөгжилд онцгой гавьяа байгуулж, бодитой хувь нэмэр оруулснаас бусад тэмдэглэлт /Шинэ жил, Цагаан сар, Улсын баяр наадам, Эмэгтэйчүүдийн баяр, Цэргийн баяр/ баяраар олгох ИТХ-ын хүндэт жуух бичгийн шагналын дагалдах мөнгийг тухайн байгууллага хариуцана.

-----oOo-----oOo-----oOo-----

-----oOo-----